НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Баянголын гудамж-1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: 7017-0109
http://www.shd.mn

2020.05.12 № 06/2241

танай ____________-ны №____________-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
АЛБАНД

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/583 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн нийтийн эзэмшлийн зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажлын зураг төсөв боловсруулах даалгавар болон захирамжийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ..9... хуудастай.

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА А.БАТСАЙХАН

9019110316 9091904

1180201353

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр | Дугаар А/583 | Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019-2020 он дамжин санхүүжих Сонгинохайрхан дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажлын жагсаалтыг хавсралт ёсоор баталж, уг төсөл, арга хэмжээний эрхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгө 438,600,000 /дөрвөн зуун гучин найман сая зургаан зуун мянга/ төгрөгийг "Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019-2020 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын 58.1.16-ын "1"-т тусгагдсан "Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажил"-ын хөрөнгөөс холбогдох хууль журамд нийцсэнийг үндэслэн санхүүжүүлэх эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Н.Отгонбаяр/-т, эрх нээсний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т тус тус зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ш.Үнэнбат/-т тус тус даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/377 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2020 оны
4 дүгээр сарын 20-ны өдрийн
А/583 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2019-2020 ОН ДАМЖИН САНХҮҮЖИХ СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙД ЯВГАН ХҮНИЙ ЗАМ ШИНЭЭР ТАВИХ, ЗАСВАРЛАХ АЖЛЫН ЖАГСААЛТ

/Төгрөг/

| № | Төсөл арга хэмжээний нэр, байршил | Хугацаа | Хүчин чадал /м2/ | Төсөвт өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | 65 дугаар сургуулийн баруун тал /БН 4-23 тоотоос 42-35 тоот хүртэлх/ явган хүний зам барих /СХД, 3 дугаар хороо/ | 2020 | 750 | 34,425,000 |
| 2 | Аптаун вилла хотхоны урд талд явган хүний зам барих /СХД, 4 дүгээр хороо/ | 2020 | 300 | 13,770,000 |
| 3 | Баянголын 47 дугаар гудамж орчим явган хүний зам барих /СХД, 5 дугаар хороо/ | 2020 | 375 | 17,212,500 |
| 4 | Хилчин хотхоны арын зам дагуу явган хүний зам /СХД, 7 дугаар хороо/ | 2020 | 750 | 45,900,000 |
| 5 | Одонтын 6 дугаар гудамж, 4-22 тоот орчим явган хүний зам барих /СХД, 25 дугаар хороо/ | 2020 | 270 | 12,393,000 |
| 6 | Нефть гудамж 2, 3-н 30 дугаар байрны орчим явган хүний зам барих /СХД, 20 дугаар хороо/ | 2020 | 168 | 7,711,200 |
| 7 | Нефть гудамж 228 дугаар цэцэрлэгийн ард явган зам барих /СХД, 20 дугаар хороо/ | 2020 | 168 | 7,711,200 |
| 8 | Шинэ цэргийн хотхоны 4 дүгээр байрны ардаас 73, 7 дугаар байрны урд хүртэл явган зам барих /СХД, 20 дугаар хороо/ | 2020 | 384 | 17,625,600 |
| 9 | 224 дүгээр цэцэрлэгийн баруун тал явган хүний зам барих /СХД, 22 дугаар хороо/ | 2020 | 300 | 13,770,000 |
| 10 | Алтан овоо 39 дүгээр гудамжны 5 тоотоос Нарны хүүхдүүд цэцэрлэгийн урд тал хүртэл явган хүний зам барих /СХД, 26 дугаар хороо/ | 2020 | 402 | 18,451,800 |
| 11 | 104 дүгээр цэцэрлэгээс хорооны байр хүртэлх явган хүний зам засварлах /СХД, 12 дугаар хороо/ | 2020 | 300 | 7,650,000 |
| 12 | Эмээгийн зоог, Алтан мөнгөн шагай дэлгүүрийн урд талын ойр орчмын явган хүний зам засварлах /СХД, 12 дугаар хороо/ | 2020 | 525 | 13,387,500 |
| 13 | 10 дугаар байрны баруун талд явган хүний зам засварлах /СХД, 13 дугаар хороо/ | 2020 | 165 | 4,207,500 |
| 14 | 13 дугаар байр орчим явган хүний зам засварлах /СХД, 13 дугаар хороо/ | 2020 | 54 | 1,377,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | 12 дугаар байрны хойд талд явган хүний зам засварлах /СХД, 14 дүгээр хороо/ | 2020 | 42 | 1,071,000 |
| 16 | 12б байрны хойд талд явган хүний зам засварлах /СХД, 14 дүгээр хороо/ | 2020 | 28 | 714,000 |
| 17 | 12а байрны урд талд явган хүний зам засварлах /СХД, 14 дүгээр хороо/ | 2020 | 19 | 484,500 |
| 18 | Залуус гудамжинд явган хүний зам засварлах /СХД, 14 дүгээр хороо/ | 2020 | 45 | 1,147,500 |
| 19 | 13 дугаар байрны зүүн талд явган хүний зам засварлах /СХД, 14 дүгээр хороо/ | 2020 | 10 | 255,000 |
| 20 | 39 дүгээр байрнаас зүүн тийш 14 дүгээр байрны зогсоол хүртэл явган хүний зам засварлах /СХД, 14 дүгээр хороо/ | 2020 | 34 | 867,000 |
| 21 | 12а байрны баруун талд явган хүний зам засварлах /СХД, 14 дүгээр хороо/ | 2020 | 40 | 1,104,405 |
| 22 | 86 дугаар сургуулийн арын хувийн эзэмшлийн байрнуудын ард явган хүний зам засварлах /СХД, 15 дугаар хороо/ | 2020 | 450 | 11,475,000 |
| 23 | Элэг судлалын клиник төвийн өмнөх явган хүний зам засварлах /СХД, 15 дугаар хороо/ | 2020 | 400 | 10,200,000 |
| 24 | 119 дүгээр цэцэрлэгийн орчим явган хүний зам засварлах /СХД, 16 дугаар хороо/ | 2020 | 450 | 11,475,000 |
| 25 | 113 дугаар цэцэрлэгийн баруун талд явган хүний зам засварлах /СХД, 16 дугаар хороо/ | 2020 | 30 | 765,000 |
| 26 | 26 дугаар байрны ард явган хүний зам засварлах /СХД, 16 дугаар хороо/ | 2020 | 90 | 2,295,000 |
| 27 | 27 дугаар байрны ард, 28, 29 дүгээр байр орчимд явган хүний зам засварлах /СХД, 16 дугаар хороо/ | 2020 | 230 | 5,865,000 |
| 28 | 118 дугаар цэцэрлэг орчимд явган хүний зам засварлах /СХД, 17 дугаар хороо/ | 2020 | 100 | 2,550,000 |
| 29 | Хилчин хотхоны-4 тоотын хажууд явган хүний зам засварлах /СХД, 30 дугаар хороо/ | 2020 | 8 | 204,000 |
| 30 | ХД 21 дүгээр байрны урд талын явган хүний зам барих /СХД, 12 дугаар хороо/ | 2020 | 102 | 6,120,000 |
| 31 | 8, 9 дүгээр байрны дунд явган хүний зам барих /СХД, 13 дугаар хороо/ | 2020 | 100 | 6,000,000 |
| 32 | 58 дугаар байр дагуух явган хүний зам барих /СХД, 17 дугаар хороо/ | 2020 | 200 | 12,000,000 |
| 33 | Драгон төв орчим явган хүний зам барих /СХД, 29 дүгээр хороо/ | 2020 | 96 | 5,760,000 |
| 34 | Москва хороолол орчим явган хүний зам барих /СХД, 29 дүгээр хороо/ | 2020 | 120 | 7,200,000 |
| 35 | 34-ийн гүүрнээс хойшоо Хамбын 2 дугаар гудамжны баруун талд явган хүний зам барих /СХД, 30 дугаар хороо/ | 2020 | 435.5 | 26,130,000 |
| 36 | BSB дэлгүүр орчим явган хүний зам барих СХД, 18 дугаар хороо/ | 2020 | 73 | 4,380,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 37 | Сүмийн засмал замаас Батбуянт дэлгүүр хүртэл явган хүний зам барих /СХД, 18 дугаар хороо/ | 2020 | 54.7 | 3,282,000 |
| 38 | "Ви Ти Икс" ХХК-ны зүүн үзүүрээс ДШС ХХК-ийн баруун үзүүр хүртэл явган хүний зам барих /СХД, 18 дугаар хороо/ | 2020 | 64.8 | 3,886,295 |
| 39 | "Намуун" пабаас 12 дугаар сургууль, 12 дугаар сургуулиас шинэ зам хүртэл явган хүний зам барих /СХД, 18 дугаар хороо/ | 2020 | 336 | 20,160,000 |
| 40 | 13а байрнаас 13б байр хүртэл явган хүний зам барих /СХД, 18 дугаар хороо/ | 2020 | 225 | 13,500,000 |
| 41 | 55 дугаар цэцэрлэгийн зүүн урд үзүүрээс баруун урд үзүүр хүртэл явган хүний зам барих /СХД, 18 дугаар хороо/ | 2020 | 103.2 | 6,192,000 |
| 42 | 42 дугаар сургуулийн баруун талын төв замын дагуу явган хүний зам засварлах /СХД, 2 дугаар хороо/ | 2020 | 300 | 15,000,000 |
| 43 | Их наран 7 дугаар гудамжинд явган хүний зам засварлах /СХД, 4 дүгээр хороо/ | 2020 | 200 | 10,000,000 |
| 44 | Угсармал 5 дугаар байрны орчимд явган хүний зам засварлах /СХД, 18 дугаар хороо/ | 2020 | 58 | 2,900,000 |
| 45 | 8 дугаар байрны хойд үзүүрээс Од цайны газар хүртэл явган хүний зам засварлах /СХД, 18 дугаар хороо/ | 2020 | 81 | 4,050,000 |
| 46 | 2 дугаар байрны орчимд явган хүний зам засварлах /СХД 18 дүгээр хороо/ | 2020 | 90 | 4,500,000 |
| 47 | "Алдар Трейд" ХХК-ийн орчимд явган хүний зам засварлах /СХД, 19 дүгээр хороо/ | 2020 | 34.5 | 1,725,000 |
| 48 | Үйлдвэрчний эвлэлийн гудамж, 2-58 дугаар байрны 1, 2, 4 дугаар орцны урд явган хүний зам засварлах /СХД, 19 дүгээр хороо/ | 2020 | 75 | 3,750,000 |
| 49 | 1, 6 дугаар хэсэгт явган хүний зам засварлах /СХД, 27 дугаар хороо/ | 2020 | 320 | 16,000,000 |
| | Нийт дүн | | 9,955.7 | 438,600,000 |

**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 10 өдөр | Дугаар А/256 | Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4, 47.6 дахь хэсэг, нийслэлийн Засаг даргын 2019 оны А/377 дугаар захирамж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны А/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Н.Мөнгөн-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ж.САНДАГСҮРЭН

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2019 оны....05....-р сарын....10.....-ний өдрийн
A/256.-р захирамжийн нэгдүгээр хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|---|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Н.Мөнгөн-Эрдэнэ | Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Ө.Норовдэмид | Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | Ж.Энхтөгсмаа | Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн |
| | Г.Нацагням | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилогдсон иргэн |
| Нарийн бичгийн дарга: | Д.Жаргалмандах | Худалдан авах ажиллагааны албаны барилгын инженер |